



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/159

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.7 дугаар зүйл, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13 дах заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хог хаягдлын тухай хууль 9 дугаар зүйлийн 9.3.1, 9.3.8, 9.3.10 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3, 7.3.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12-р сарын 02 өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ойн сан бүхий газар, Дэлгэр мөрөн голын эрэг дагуу ойн зурвасын хог цэвэрлэн хамгаалалтын зурваст нөхөн тарилт хийх, хог хаягдлыг устгах, аймгийн төвийн хогийн цэгийн ойролцоох газруудын хог хаягдлыг цэвэрлэх, газрын хог хаягдал түрэх цэвэрлэх ажилд 50,000,000.0 (тавин сая) төгрөг,


2. Цас ихээр орж, зудын нөхцөл байдал үүссэн газар нутагт ховор, нэн ховор зэрлэг амьтдад зориулан өвс, тэжээл, хужир давс тавих, орон нутгийн онцлогоос хамааран усан хангамж нэмэгдүүлэх, зудын улмаас хорогдсон мал, зэрлэг амьтны сэг зэм устгах, булшлах ажлыг орон нутгийн мал эмнэлгийн мэргэжлийн байгууллагын зааврын дор зохион байгуулж, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж устгах булшлах цэгийг усан сан бүхий газрын хамгаалалтын бүсээс гадна байршуулах ажилд 35,000,000.0 (гучин таван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

3. Ойн мэргэжлийн байгууллагуудын 2022 оны өөрийн хөрөнгөөр хийх ойжуулалтыг аймагт татан төвлөрүүлсэн орлогын он дамжсан үлдэгдлээс гаргахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал) -д үүрэг болгосугай.

4. Батлагдсан зардлыг холбогдох данснаас гаргаж хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, баримтын бүрдлийг ханган, тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч (Д.Лхамжаргал) үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн засаг даргын орлогч (М.Хуягбаатар) -д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010473